

Ж.Ганчимэг

Шашин судлалын тэнхмийн докторант,  
Буддын соёл судалгааны төвийн  
эрдэм шинжилгээний ажилтан.

**БУДДЫН ТӨР ЁСНЫ ШАСТИРТ •  
ТӨРИЙН ТҮШЭЭ ХҮНИЙ ШИНЖИЙГ АВЧ ҮЗЭХ НЬ**

**Оршил:** “Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас” гэсэн мэргэн чиг шугамыг баримтлан Монголчууд ухааныг уралдуулан, уран гарыг хөдөлгөж өөрсдийн нандин түүхийг бүтээсээр ирсэн түүхтэй. Энэ мэргэн чиг шугамын нэгээхэн үндсэн уг сурвалж сургаал номлол нь Төвд, Монгол Данжуураар уламжлагдан ирсэн эртний Энэтхэгийн сэтгэгч Нагаржунагийн төрт ёсны алдарт найман шастираас<sup>1</sup> улбаатай, Энэтхэг, Төвд, Монгол сэтгэгчдийн олон тооны ном зохиол, шасдируудад төрт ёсны баримтлах үндсэн үзэл баримтлал, арга зүйн үндэслэлийг аль хэдийнээ боловсруулж өнөө бидэнд уламжлан хүрч ирсэн билээ.

Нэг үеэ бодоход манайд бурхны шашин нилээдгүй сэргэх үйл явц сайжирсан боловч бурхны шашны ном зохиол, сурвалж бичгийн судалгаа дутагдалтай хийгээд түүнийг эрдэмтэн, судлаачидаас эдүүгээшүүлэн тайлбарласан, түүнийгээ Монголын онцлогтой хөрсөн дээр буулган Монголын нийгмийн бүхий л салбарт ашиглах бодлого боловсруулах ажил дутмаг, эхлэл төдий л хэмжээнд явсаар байна. Судалгааны энэ чухал ажилд дуслын төдий ч болов нэмэрлэх үүднээс төр гэдэг өргөн багтаамжит тогооноос төрийн түшээ хүний үндсэн шинжийг сугалан авч, буддын төрт ёсны шасдируудад уг судлагдахуунаа тулгуурлан авч үзэн энэхүү өгүүлэлд товч өгүүлэхийг оролдлоо.

<sup>1</sup> - Lugs kyi bsTan bcos skye bo gso thig. Дэргэ Данжуурын “Нацогын” Ngo буюу 203-р боть. 113a4-116b4, Монгол Данжуурын урлахуй ухааны аймгийн “Go” буюу 211-р боть. 246a1-252a8

- Lugs kyi bstan bcos shes rab sdong bu. Дэргэ Данжуурын “Ngo” буюу 203-р боть. 103a7-113a; Монгол Данжуурын урлахуйн аймгийн “Go” буюу 211-р боть. 229a-246a1

- Dri ma med pa'i dris lan rin po che'i phreng pa. Дэргэ Данжуурын “Нацогын” “Ngo” буюу 203-р боть. 126a6-127b6; Монгол Данжуурын урлахуйн аймгийн “Go” буюу 211-р боть, 267b13-270a19.

- Tsigs su bcad pa brgya pa. Дэргэ Данжуурын “Нацогын” “Ngo” буюу 203-р боть. 122a3-126a6; Монгол Данжуурын урлахуйн аймгийн “Go” буюу 211-р боть, 260b20-267b12

- shes rab brgya pa. Дэргэ Данжуурын “Нацогын” “Ngo” буюу 203-р боть. 99b4-103a7; Монгол Данжуурын урлахуйн аймгийн “Go” буюу 211-р боть, 222b17-229a3;

- Tsigs su bcad pa'i mdzod. Дэргэ Данжуурын “Нацогын” “Ngo” буюу 203-р боть. 116b5-122a3; Монгол Данжуурын урлахуйн аймгийн “Go” буюу 211-р боть, 252a9-260b19;

- Ca na ka'i rgyal po'i lugs kyi bstan bcos. Дэргэ Данжуурын “Нацогын” “Ngo” буюу 203-р боть. 127b6-137b6; Монгол Данжуурын урлахуйн аймгийн “Go” буюу 211-р боть, 270a20-287b5

- Lugs kyi bstan bcos. Дэргэ Данжуурын “Нацогын” “Ngo” буюу 203-р боть. 137b6-143a7; Монгол Данжуурын урлахуйн аймгийн “Go” буюу 211-р боть, 287b5-297a18



**Түлхүүр үг:** улс төр судлал, мадхъямака, хорин суртал, элитийн онол,

**Хэлцэмж:** Эртний судар бичгүүдэд боловсруулан тавьсан төрийн түшээ хүний шинж төлөв, үүрэг, үйл ажиллагаа гэсэн олон талт чанаруудаас төрийн өгсөх, уруудах явц шалтгаалах тухай монгол мэргэдийн туурвисан ном сударт заан сургаж, уг сургаалаар бид явсаар ирснийг түүх өгүүлнэ. Ер ямар ч нөхцөлд төрийн түшээ хүн бол төрийн тэргүүний үнэнч туслагч, улс орны тусгаар тогтнол, тухайн ард түмний эв нэгдлийн төлөө тууштай тэмцэгч байдаг, төр, түмэн хоёрыг холбон дамнуургалах гүүр нь билээ.

Төр ёсны талаархи дорно дахины, тэр дундаа Энэтхэг, Төвд, Монгол ном судруудад төрийн түшээ хүний шинж чанар, эрхэмлэвээс зохих зүйлсийг илэрхийлэн зааж, түүнийгээ мөрдөж ирсэн уламжлал бий. Жишээлбэл: Энэтхэгийн "Масуракша хааны төрийн шастир"-ын XX бадаг<sup>1</sup>:

Арслангийн нэг хийгээд чуучлайн нэг

Тахианы дөрвөн суртал

Хон хэрээний тав хийгээд нохойн зургаа

Илжигний гурван суртал - нийт хорин суртал төгссөн байхыг нийт хүмүүст, ялангуяа төр түшэлцэж байгаа түшээдэд онцгойлон заасан байдаг.

Арслангийн нэг суртал гэдэгт аливаа ажил хэргийн олон цөөн, их бага, бэрхшээл саадыг үл хэрэгсэн, хэрэв хийе гэж зорих юм бол хамаг бүх хэрэг үйлсийг бүтээхийн төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр зориглон орж, эрэлхэн ялж гарах ингэж арслангийн гагц зоригоос үлгэр авч хичээхийг сургасан байна.

Чуучлай буюу цахлайн нэг суртал гэдэг нь аливаа ажил хэргийг хийхдээ насад урьдаас сайтар шинжлээд, орон цагтай нь тааруулан анаж, оломгой цэцэн хийхийг уснаас дээш үсрэх загасны тэр агшинг сайтар анаж, гэтэн мярааж шүүрэх цахлайн уран аргаас үлгэр авч хичээхийг;

Тахианы дөрвөн суртал гэдэг нь тахиа мэт эрт босогч, хэргийн төлөө байлдаанч, үр цурав садандаа идээ хоолыг ижил тэгш түгээгч, эмээн машид эдлэгч тэр дөрвөн суртлаас үлгэр авч суралцахыг;

Хэрээний таван суртал гэдэг нь хэрээ мэт далд хурьцагч, хэцүү сүрхий, цагтаан орон үүрээ засагч, хашир сэтгэмжтэй, итгэшгүй сэжигтэй энэ таван суртлаас үлгэр авч суралцахыг өгүүлсэн байна.

Нохойн зургаан суртал гэдэг нь нохой мэт олж идээд, өчүүхэнд ханах, бөх унтаад түргэн сэрэх, дайсанд баатар, садандаа ижилсэг эл зургаагаас үлгэр авч суралцах;

Илжигний гурван суртал гэдэг нь илжиг мэт ачааны ихийг даах, халуун хүйтэн, зовлон жаргалыг тэсэх, насад болилон мэдэх эл гурван шинжээс үлгэр авч суралцахыг заажээ. Ийнхүү адгуус амьтанд байх онцгой чухаг шинжүүдийг түүвэрлэн цогцлоож хүний эрхэмлэн дээдлэх чанаруудыг бүгдийг шингээсэн шилдэг удирдагч болох талаар сургаж байв.

Буддын их сэтгэгч Нагаржуна түшмэл хүнд байвал зохих шинжийг заан сургахдаа: билгийг сурч эзэмших, бусдад туслахыг хичээх хоёрыг гол

<sup>1</sup> Монгол Данжуур, Урлахуй ухааны аймаг, боть 211, 28765-297а18



болгож, мэдлэггүй мунхаг байх, хар амиа бодох хоёрыг эрс жигшин шүүмжилжээ. “Зуун билиг”-хэмээх төрийн шастиртаа:

“Билгийн нүдэн нээгдсэн хүнд  
Бууруулагчин магад эвдрэн одмуу...

Билгийн хүчнээс ангижрагсад

Бусдын боол болохоос өөр юун” гэж билгийг машид чухалчлаад, билиг үгүй бол хаад, түшмэд ч бусдын эрхэнд хөтлөгдөнө хэмээн сүрлэг их заантай зүйрлэсэн байна.

Эндээс үзэхэд төрийн түшээ хүн билгийг судалсанаараа аливаа асуудлыг оюун ухаандаа тунгаан бодож хүч үл хэрэглэх хүнлэг, энэрэнгүй зарчмыг баримтлан хүний хөгжлийн харьцангуй дээд төвшний сэтгэхүйг харуулах хүн хэдий чинээ их хөгжинө төдий чинээ хүн шинжээрээ байж аливаа тулгарсан асуудлыг оюун ухаан, ёс суртахуунаараа явдал үйлтэйгээ шүтэн барилдуулж байж шийдэж сурах нь одоогийн нийгэмд хэрэгжүүлэхэд хэцүү зүйл ч бид ирээдүйд хүссэн ч хүсээгүй ч ийм хөгжлийн замд орох учиртай.

Цааш нь бусдад туслахыг эрхэм болгохгүй, зөвхөн хар амиа бодож, бөөцийлөгчид хичнээн хичээвч, өөрөө хэрэг бүтэж байна гэж бодохоос бус, үнэндээ бүтсэн үйлс үгүй байдаг гэдгийг цусаа сорсоор байгаад барагдагч гүр хорхойтой зүйрлэн үзжээ.

Нагаржуна гэгээнтэн түшмэл хүний хувийн зан чанар ямар байхыг заан өгүүлэхдээ:

“Залуу боловч хөгшидийн амарлангуйд баясагч,  
Мэргэн боловч мэдэмхий омоггүй,  
Их сүр жавхлант боловч хүлцэн номхотгосон аальт,  
Улам өндөр боловч дээрэнхүй омоггүй,  
Насад амьтныг туслахуйяа таалагчид,  
Эрдэнэ зул мэт эрхэн” гэж онцлон сургасан байна<sup>1</sup>.

Аль ч улс үндэстэн, тэр дундаа Монгол төрийн цаг үеийн илэрхийлэл нь юуны өмнө эзэн хаан байсан, тэрчлэн төр хүчтэй байхын нэгэн углуурга нь мэргэн цэцэн, шударга чигч, зусарч зангүй төрийн түшмэд байсан. Монголын уламжлалт төрийн тогтолцоонд хаст төрийн тулгуур гурван багана нь хаан, түшмэд, түмэн ард бөгөөд харилцан бие биеийнхээ үзэл бодол, сургаал номлолыг гурвалжлан шүтэлцүүлэх, тэрчлэн харилцан бие биедээ итгэл үнэмшил үзүүлэн үнэнч шударга байх нь төрөө төвшин жолоодож түмнээ амгалан байлгах үндэс хэмээн үзнэ. “Эзэн гэгээн, сайд мэргэн, түмэн иргэн зөвэргүү” гэсэн зарчмыг баримтлах нь мандах төрийн шинж гэж үзэх бөгөөд төрийн түшээ хүнд байх үндсэн шинжийн нэн чухал нь төрийг шударгаар засан явуулж, олны сэтгэлийг жолоодох болой гэж судар бичигт дурдсан байдаг. Энэ талаар XX зууны эхэн үеийн монголын улс төрийн нэрт сэтгэгч Ч.Дэмчигдорж “Эрдэнэт толь” шастиртаа:

“... Эзэн хааны зарлигт аливаа их, бага зэрэг тушаалыг дагаж суугчид түшмэд суугчид бүхий бөгөөд зуун зүйлийн тушаал хэдий тус тусдаа адилгүй боловч мөнхүү тус тусдаан өөрөө тодорхой буй. Тиймийн тул өөр өөрийн тушаалын доторх хүчнээ гүйцэтгэхийг шударга хэмээнэ, журам

<sup>1</sup> Г.Лувсанцэрэн, Наргаржунагийн философийн үзэл, УБ., 1981, 45-46 дахь тал.



хэмээнэ”<sup>2</sup> гэж өгүүлсэнээс үзэхэд төрд шударга байх нь нэн эрхэм бөгөөд шударга байхын гол агуулга нь монголын феодалын нэгдсэн гүрэн тогтож байх үеийн ухаарлаар бол эзэн хаандаа үнэнч байх нь төрд үнэнч байх, шударга байхын агуулга болж байжээ. Түүнчлэн “Аливаа юман дээр тушаалт бүхий ард нь доорд тушаалын ардыг сонсохуйд гоёч хүнийг хэрэглэх хийгээд нүүр тал харахыг сайтар тэвчиж, эрхэм доордыг ялгахгүй, эрхгүй шударга мэргэн эрдэмтэн баатар гавъяа зүтгэл бүхий ардыг хэрэглэтүгэй. Аяа, түшмэл болсон ард гагц “Шударга, гэгээн, цээр” хэмээх гурван үгийг сахиж чадваас тушаалын доторхи аливаа явдал өөрөө тодорхой засагдана гэжээ”<sup>3</sup>. Түшмэл хүн билгийг машид чухалчлан гэгээн оюунаар аливаа хэргийг мэргэнээр нягтлан ухаараад шударга чигээр шийдэн явуулж, амин хувийг бодох явдлыг цээрлэн, таслан зогсоогоод, гагц төрийн хэргийг онцгой чухалчлан, тулгар төрийг бэхжүүлэх байр сууринаас бүхнийг үнэлж цэгнэж дор бүрнээ дээрх зарчмыг баримталвал зохино.

“Мандах төрийн сайд түшмэд өөрийн ял гэмийг илэрхийлэн үзүүлнэ  
Муудах төрийн эзэн, түшмэд биеийн эндүүгээ баллаж  
арилгана”<sup>1</sup> хэмээснээс

төрийн хэргийг хөнгөлөн эрх ямбад эрэмшин, самуун зугаа цэнгэлийг хэтрүүлэн, хоосон үгэнд хууртан басхүү хуурч, сайд түшмэд нь зусар залихай, засдаг зангаар завсрын завшааныг олж хутган, амин хувийн эрх ашиг, албан суурийг хөөцөлдөх нь буурах төрийн шинж хэмээн цээрлэж байв.

Алтны чанарыг барьж, үрж, шарж, хайлж дөрвөн шинжлэлээр ялган таних зарчмыг баримталж ашид амраг болох нөхөр, түшмэд садны байдлыг бие, хэл, сэтгэлийн гурван үүдний явдал, ялгалаар нь сайтар шинжлэн мэдэх хэрэгтэй ба сайд түшмэдийг бэлтгэж хүмүүжүүлэх, шилдэг иргэдийг төрийн албанд тохоон зүтгүүлэх, зөв хүнээ сонгон олох нь Монгол төрийн онцгой анхаарах зүйлийн нэг юм. Тиймээс ч Чингис хаан хүмүүсийг зөв сонгон авч чадаж байсан ба их хаан ураг, төрөл, ойр дотны хүмүүсээрээ өөрийгөө тойруулахыг урьдал болгосонгүй, зөвхөн язгуур угсааг бодсонгүй, нүүр тал харсангүй, харин хүний эрдэм чадал шударга зүтгэлийг эн тэргүүнд тавьдаг байсан нь түүхэн баримтаас илэрхий. 1206 онд Хаант Монгол улсыг тунхаглах үед Чингис хаан нэр дуудан шагнаж, мянганы ноёноор томилсон 88 гавъяатныг авч үзэхэд 30 гаруй овог, аймгийн хүмүүсээс бүрдсэн байсны

<sup>2</sup> Бурханы их хөлгөн номын журмыг батжуулсан ертөнц дахиныг сургах, Эрдэнэт толь хэмээх шашдир оршвой. Ч.Дэмчигдорж /Дандаа/, УБ., 2002, 22 дахь тал.

<sup>3</sup> Мөн тэнд. 23 дахь тал.

<sup>4</sup> В.Инжиннаши. “Хөх судар”, Тэргүүн, дэд, гутгаар дэвтэр. Өвөр Монголын хэвлэл. 437 дахь тал.



дотор унаган овгоос гадна дайсагнаж байсан хийгээд харь хэмээн тооцож байсан овгийн хүмүүс ч орсон байдаг.

Дорно дахины сэтгэлгээ, буддын төрт ёсны шастир судруудад заан сургаж, мөрдөж байсан төрийн түшээ түшмэл хүнд байвал зохих шинж түүнд тавигдах шаардлага нь эдүгээ ч ач холбогдолоо алдаагүй байна гэж үзэж болно. Эдгээр нь орчин үеийн төрийн зүтгэлтэн хүнд байвал зохих эрхэм шинж чанарын нэг байсаар байна.

Удирдлагын орчин цагийн шинжлэх ухаанд ч төрийн түшээ хүн буюу удирдах ажилтан хүний шинж төрхийн талаар өдий төдий үзэл баримтлал бий. Эрдэмтэд, сэтгэл судлаачид орчин цагийн олон зуун шилдэг сайн удирдах ажилтныг судлаад, тэдэнд дараахь шинж байгааг тогтоосон байна. Үүнд:

1. Тухайн салбарыг сайтар мэдэхийн хэрээр өргөн цар хүрээтэй сэтгэн бодох,
2. Ажил бодлогынхоо зарчимд хатуу зогсохын хэрээр эсрэг үзэл бодлыг хүлээн авах, ажилдаа нэвтрүүлэх,
3. Бусдын шахалтад автагдахгүй байхын хэрээр тэдэнтэй хэвийн байдлаар харьцах,
4. Эсрэг талын хүмүүстэй өрсөлдөхийн хэрээр тэднийг өөртөө татах,
5. Шинэ үзэл санааг эрчимтэй авахын хэрээр үл гүйцэлдэх хоосон санаанд хууртахгүй байх,
6. Зоримог шийдэмгий алхам хийхийн хэрээр алдаа дутагдал гаргахгүй байх,
7. Өндөр шаардлагатай байхын хэрээр эелдэг, ая эвийг олж харьцах өндөр чадварыг эзэмшсэн байх учиртай.

Шилдэг сайн удирдагч хүн сэтгэл зүйн дараахь шинж чанартай байх учиртайг судлаачид тогтоосон байна. Үүнд:

- бэрхшээлээс үл ухрах
- ухаалаг шийдэмгий алхам хийх
- идэвх санаачлага, цаг зуурын аяст үл автагдах
- шинж нөхцөлд зохицох
- өөртөө шүүмжлэлтэй хандах
- өөртөө болон бусдад өндөр шаардлага тавих
- ажилд оршиж буй алдаа дутагдлыг олж харах
- хэлсэн үгэндээ хүрэх
- ямар ч хүнд нөхцөлд ажиллах
- шинээр дэвшигдэн гарах асуудлыг шийдвэрлэх
- төвөгтэй нөхцөл байдалд өөрийгөө эзэмдэх
- ямар ч нөхцөл байдалд өөдрөг сэтгэлээр хандах
- асуудлыг цаг алдалгүй биеэ дааж, зоримог шийдвэрлэх, нөхцөл

байдалд тохируулан ажиллах аргаа солих зэрэг шинж чанарууд ордог аж<sup>1</sup>.

Эл бүгдээс үзэхэд орчин үеийн төрийн түшээ хүнд өрсөлдөгч талуудын аль алины ашиг сонирхол, үзэл бодлыг харьцуулан бодож тунгаан ойлгож, түүнийг хүлээн зөвшөөрөхөөс гадна ухаалгаар шүтэлцүүлэн

<sup>1</sup> Психологические тесты. М., 1994, 49 тал.



ажиллаж өөрийн ажил үйл, төрх байдлын хувьд гагц төрийн хэргийг онцгой чухалчлан, тулгар төрийг бэхжүүлэх байр сууринаас төрийн бодлогод үнэнч, бүх талын өндөр боловсролтой, өргөн цар хүрээтэй сэтгэлгээтэй байх, ажилаа эрхлэх өндөр чадвартай, хувийн шинжийн хувьд бүрэн төлөвшсөн байж гэмээнэ төрийн түшээ сайтар бэлтгэгдсэн боловсон хүчин бэлтгэгдэж улс орон, ард түмэндээ зүтгэж "Төр түвшин, түмэн ард амгалан" байж чадна.

**The Buddhist Nithisastras on main qualities of pillar of state.**  
(resume)

Many complete qualities of the pillar of the state that respecting knowledge, protecting the masses, settling the state and realizing the human principles.

**Ном зүй:**

*II. Эх сурвалж*

1. Ард түмний ариун ёсон оршвой, (Тарва бандитын зохиол) Нийслэл Хүрээ, 1923
2. Ч.Дэмчигдорж, Эрдэнэт толь, УБ.,
3. Монгол улсын Арван буянт номын цагаан түүх, УБ., 1998
4. Нагаржуна, Эрдэнийн эрих, - Монгол Данжуур, 182 дугаар боть
5. Нагаржуна, Ардыг тэжээхүй рашааны дусал, - Монгол Данжуур, 211 дүгээр боть
6. Нагаржуна, Зуун билиг, - Монгол Данжуур, 211 дүгээр боть
7. Нагаржуна, Билгийн гол модон, - Монгол Данжуур, 211 дүгээр боть
8. Нагаржуна, Садны захиа, - Монгол Данжуур, 182 дугаар боть
9. Нагаржуна, Садны захиа, - Төвд Данжуур, 203 дугаар боть
10. Нагаржуна, Масуракша хааны шастар, - Монгол Данжуур, 211 дүгээр боть
11. Нагаржуна, Дундад үзлийн ухааны чуулган, УБ., 2002

*II. Судалгааны бүтээлүүд*

1. Буддын философийн түүхээс, УБ., 1987
2. Ө.Гүндсамбуу, Хаанд илгээсэн захиа, УБ., 2001
3. Г.Лувсанцэрэн, Нагаржунагийн гүн ухааны үзэл, УБ., 1981
4. Г.Лувсанцэрэн, Төв үзэл, төвшин бодлого, УБ., 1994
5. Ц.Эрдэмт, Төрийн тухай монгол онол, УБ., 2002

*Англи хэлээр*

1. The 14<sup>th</sup> Dalai Lama, Kindness, Clarity and Insight, New Delhi, 1997
2. Golden Zephyr. Instructions from Spiritual Friend Nagarjuna and Lama Mipham, transl. Leslie Kawamura, Berkeley, 1975
3. "Nagarjuna's letter" commentary Venerable Rendawa., transl. by Geshe Lobsang Tharchin and Artemus B.Engle, New Delhi, 1995